



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/37

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Үндэсний Олон Нийтийн радио телевизийн Монгол түмний мэнд нэвтрүүлгийн төлбөрт 4 500 000 төгрөг, нэвтрүүлэгт оролцогч нутгийн зөвлөлийн тэргүүлэгчид, урлагийн баг, оролцогч ахмадуудын халдвар хамгааллын зардалд 895 000 төгрөг, урлагийн багийн байр, хоолны зардалд 2 335 000 төгрөгийг хасвралтаар баталж тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 7 730 000 төгрөг (Долоон сая долоон зуун гучин мянган)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 19-ний өдрийн
А/37 дугаар захирамжийн хавсралт



АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Тоног төхөөрөмжийн нэр төрөл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1.	Монгол түмний мэнд нэвтрүүлгийн төлбөр	ш	1	4 500 000	4 500.0
2.	Оношлуур /SARS-CoV-2 №1 Герман/	ш	50	17 900	895.0
3.	Ховд аймгийн ХДТ-н уран бүтээлчид /5хүн/-нийн байр, хоолны зардал	өрөө/хоног	3	255 000	765.0
4.		өрөө/хоног	4	205 000	820.0
5.		Хүн/хоног	20	37 500	750.0
ДҮН					7 730.0

-oOo-